ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДАА-2025/115/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дархан-Уул аймаг<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:<br>Утас: 70378845<br>Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: С.Батцэцэг<br>Утас: 70373089<br>Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn<br><br>Аудитор: Э.Эрдэнэбат<br>Утас: 99352099<br>Цахим хаяг: tsesb.audit@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .... 14
4. АУДИТЫН ТАЙЛАН .... 16
4.1 Ерөнхий зүйл .... 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .... 17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .... 17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .... 18
4.5.1 Завсрын аудитын талаар .... 18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .... 19
5.2 Албан шаардлага .... 19
5.3 Зөвлөмж .... 19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .... 20

**Товчилсонүгийнжагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ДЭМБ | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХӨСҮТ | Халдварт өвчин судлалын үндэсний төв |

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 80

танай ______________-ны №______________ -т

ДАРХАН УУЛ АЙМГИЙН ХОНГОР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
С.МӨНГӨНТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэхбайгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант хугацаанд ЭМ-ийн сайдын 2024 оны А/44, А/60, А/400 тоот тушаалаар 213,909.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, Хонгор сумын ИТХ-ын 2024 оны 19 тоот тогтоолоор 90,162.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүйгээр хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 873,660.9 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 37.6 хувиар өссөн байна.



452502C198

**Бусад асуудал**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан-Уул аймгийн хонгор сумын Эрүүл мэндийн төвийн 20224 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 22 зорилтын 87 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг Эрүүл мэндийн газрын 4-р улирлын хяналт, шинжилгээ үнэлгээгээр 81 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **412,867,471.13** | **347,882,570.18** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **158,548,032.69** | **287,605.54** |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 158,548,032.69 | 287,605.54 |
| 3121 | төгрөг | | |
| 31211 | Төрийн сангийн харилцах | | |
| **33** | **АВЛАГА** | **22,551,353.00** | **154,156,576.83** |
| 332 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 22,551,353.00 | 154,156,576.83 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **231,768,085.44** | **193,438,387.81** |
| **351** | **Түүхий эд материал** | **111,609,594.55** | **71,625,138.06** |
| 3511 | Тусгай зориулалттай материал | - | - |
| 3513 | Эм боох материал | 111,609,594.55 | 71,625,138.06 |
| **354** | **Хангамжийн материал** | **120,158,490.89** | **121,813,249.75** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,719,302.00 | 11,344,150.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 6,664,650.00 | 6,742,910.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 14,218,000.00 | 10,381,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,815,000.00 | 3,020,000.00 |
| 3545 | Барилгын засварын материал | | - |
| 3546 | Хүнсний материал | 2,252,410.00 | 427,710.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 88,489,128.89 | 89,897,479.75 |
| 36 | НӨӨЦ БАРАА | | |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,330,008,513.35** | **1,544,771,086.14** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | | |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,330,008,513.35** | **1,544,771,086.14** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,320,966,513.15** | **1,535,237,204.90** |
| 39201 | Барилга, байгууламж орон сууц | 1,016,789,459.00 | 1,016,789,459.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (58,634,804.40) | (72,534,882.03) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 33,023,300.00 | 236,399,366.47 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (22,523,300.00) | (33,932,468.31) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 430,877,452.53 | 499,139,552.53 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (127,576,339.89) | (182,403,163.21) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 75,375,000.00 | 107,012,025.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (33,725,130.37) | (41,370,774.34) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 8,179,139.00 | 8,179,139.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (818,262.72) | (2,041,049.61) |
| 39217 | Ном | | |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **9,042,000.20** | **9,533,881.24** |
| 39301 | Программ хангамж | 1,124,300.00 | 562,150.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,124,299.80) | (70,268.76) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,042,000.00 | 9,042,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,742,875,984.48** | **1,892,653,656.32** |



XTO5438 @ 9022399

| | | | |
|---|---|---|---|
| | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **66,497,153.74** |
| | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | **66,497,153.74** |
| | Өглөг | | **23,977,184.74** |
| | Ажилчидтай холбогдсон өглөг | | 23,977,184.74 |
| | Бусад өглөг | | **42,519,969.00** |
| | Байгууллагад төлөх өглөг | | 42,519,969.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,742,875,984.48** | **1,826,156,502.58** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,742,875,984.48 | 1,826,156,502.58 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 155,925,714.83 | 155,925,714.83 |
| 51101 | Өмч: - төрийн | 155,925,714.83 | 155,925,714.83 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,145,576,273.09 | 1,228,856,791.19 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,145,576,273.09 | 1,145,576,273.09 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 83,280,518.10 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 441,373,996.56 | 441,373,996.56 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,742,875,984.48** | **1,892,653,656.32** |

ХТО5430 ⊕ 9022899

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,166,828,923.75** | **1,588,612,225.33** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **192,155,620.16** | **370,244,618.13** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 192,155,620.16 | 370,244,618.13 |
| | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 24,226,000.00 |
| | Туслах үйл ажиллагааны орлогоосс санхүүжих | | 24,106,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 182,846,662.20 | 314,616,841.87 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 9,308,957.96 | 31,401,776.26 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **974,673,303.59** | **1,218,367,607.20** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **0.00** | **0.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **58,717,300.00** | **79,400,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/ | 58,717,300.00 | 79,400,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **915,956,003.59** | **1,138,967,607.20** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 915,956,003.59 | 1,138,967,607.20 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,073,469,376.84** | **1,505,331,707.23** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,073,469,376.84** | **1,505,331,707.23** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,067,781,835.22** | **1,478,550,972.21** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **634,862,295.84** | **873,660,922.58** |
| 210101 | Үндсэн цалин | 324,595,037.81 | 437,053,947.41 |
| 210102 | Нэмэгдэл | 221,229,547.22 | 332,038,016.58 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 32,117,734.69 | 30,824,486.55 |
| 210104 | Урамшуулал | 56,919,976.12 | 73,744,472.04 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **73,765,613.65** | **108,305,261.09** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,823,018.76 | 71,827,650.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,519,378.25 | 9,229,027.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,211,142.64 | 4,493,212.60 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,290,224.90 | 4,551,134.10 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,921,849.10 | 18,204,236.40 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **53,698,258.38** | **70,822,594.98** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,732,173.38 | 7,935,667.98 |
| 210302 | Түлш, халаалт | 42,971,159.00 | 59,139,508.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,994,926.00 | 3,747,419.00 |
| 210304 | байрны түрээс | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **59,998,279.00** | **65,573,267.20** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,664,350.00 | 8,271,402.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,465,000.00 | 24,795,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,198,815.00 | 2,117,286.60 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 430,000.00 | 1,410,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,611,380.00 | 28,979,578.60 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 18,628,734.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | **136,734,512.58** | **192,236,332.48** |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 109,347,172.58 | 158,226,311.68 |
| 210502 | Хоол хүнс | 27,387,340.00 | 29,421,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 4,588,620.80 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **0.00** | **38,654,263.80** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 3,341,531.00 |
| 210604 | Урсгал засвар | 0.00 | 35,312,732.80 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **650,000.00** | **2,942,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 650,000.00 | 2,942,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,307,259.00** | **13,876,431.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 470,000.00 | 12,020,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 184,500.00 | 232,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 149,337.00 | 88,837.00 |
| 210805 | тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 55,000.00 |
| 210806 | мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 98,422.00 | 130,394.00 |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 0.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **105,765,616.77** | **112,479,899.08** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,505,000.00 | 4,475,830.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 0.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 96,260,616.77 | 108,004,069.08 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5,687,541.62** | **26,780,735.02** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **0.00** | **0.00** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **668,500.00** | **24,078,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 24,078,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 668,500.00 | 0.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **5,019,041.62** | **2,702,735.02** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,019,041.62 | 2,702,735.02 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **93,359,546.91** | **83,280,518.10** |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 0.00 | |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 0.00 | |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН | 0.00 | |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **93,359,546.91** | **83,280,518.10** |

ХТО5430 2022899

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | ***ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ*** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **952,121,950.59** | **1,110,988,383.37** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | **24,226,000.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | - | **24,226,000.00** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | | 120,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 24,106,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | **952,121,950.59** | **1,086,762,383.37** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | - | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **58,717,300.00** | **79,400,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 58,717,300.00 | 79,400,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **893,404,650.59** | **1,007,362,383.37** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 893,404,650.59 | 1,007,362,383.37 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **965,058,242.87** | **1,261,099,010.52** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **965,058,242.87** | **1,261,099,010.52** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **964,389,742.87** | **1,234,318,275.50** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал** | **634,862,295.84** | **862,039,950.83** |
| 210101 | Үндсэн цалин | 324,595,037.81 | 425,432,975.66 |
| 210102 | Нэмэгдэл | 221,229,547.22 | 332,038,016.58 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 32,117,734.69 | 30,824,486.55 |
| 210104 | Урамшуулал | 56,919,976.12 | 73,744,472.04 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | - |
| **2102** | **Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **73,765,613.65** | **95,949,048.10** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын | 47,823,018.76 | 63,171,748.10 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын | 6,519,378.25 | 8,194,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ий даатгалын | 5,211,142.64 | 4,097,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын | 1,290,224.90 | 4,097,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын | 12,921,849.10 | 16,388,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **52,148,358.38** | **70,822,594.98** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,732,173.38 | 7,935,667.98 |
| 210302 | Түлш, халаалт | 42,971,159.00 | 59,139,508.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,445,026.00 | 3,747,419.00 |
| 210304 | байрны түрээс | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материал** | **34,555,965.00** | **43,025,656.60** |
| 210401 | Бичиг хэргийн зардал | 4,623,100.00 | 4,761,950.00 |
| 210402 | Тээвэр шатахуун | 24,280,000.00 | 24,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,198,815.00 | 2,117,286.60 |
| 210404 | Ном, хэвлэл | - | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 430,000.00 | 1,423,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,024,050.00 | 10,722,920.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | **127,188,931.00** | **106,803,873.99** |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 98,415,631.00 | 84,359,473.99 |
| 210502 | Хоол, хүнс | 26,001,300.00 | 21,300,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,772,000.00 | 1,144,000.00 |
| **2106** | **Эд хогшил урсгал засвар** | **20,747,220.00** | **31,301,484.00** |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 935,000.00 | 2,367,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,239,100.00 | 1,901,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,573,120.00 | 27,032,584.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **650,000.00** | **2,942,000.00** |
| 210702 | Дотоодын томилолт | 650,000.00 | 2,942,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,307,259.00** | **10,846,037.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 470,000.00 | 9,120,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 184,500.00 | 232,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 149,337.00 | 88,837.00 |
| 210805 | тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 55,000.00 |
| 210806 | мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 98,422.00 | 0.00 |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 0.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **18,164,100.00** | **10,587,630.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,164,100.00 | 10,587,630.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | - | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **668,500.00** | **24,078,000.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **-** | **-** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | - |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | - | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **668,500.00** | **24,078,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | - | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан а/хаагчдад дэмжлэг | - | 24,078,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 668,500.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт , шилжүүлэг** | **-** | **-** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **5,019,041.62** | **2,702,735.02** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,019,041.62 | 2,702,735.02 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | - |
| **3** | **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(17,955,333.90)** | **(150,110,627.15)** |
| 4 | Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн | | |
| **5** | Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн | **3,908,000.00** | **8,149,800.00** |
| | Дотоод эх үүсвэр | | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,908,000.00 | 8,149,800.00 |
| 6 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(3,908,000.00)** | **(8,149,800.00)** |
| 8 | **Нийт цэвэр мөнгөн гүйлгээ** | **(21,863,333.90)** | **(158,260,427.15)** |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 180,411,366.59 | 158,548,032.69 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 158,548,032.69 | 287,605.54 |

## Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **155,925,714.83** | **441,373,996.56** | **1,145,576,273.09** | **-** | **1,742,875,984.48** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 155,925,714.83 | 441,373,996.56 | 1,145,576,273.09 | - | **1,742,875,984.48** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | - | | - |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **155,925,714.83** | **441,373,996.56** | **1,145,576,273.09** | **-** | **1,742,875,984.48** |
| D01 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| D02 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 155,925,714.83 | 441,373,996.56 | 1,145,576,273.09 | - | **1,742,875,984.48** |
| D03 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | - |
| D04 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | - |
| D05 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| D06 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | - |
| D07 | Тайлант үеийн үр дүн | | | 83,280,518.10 | | **83,280,518.10** |
| D08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **155,925,714.83** | **441,373,996.56** | **1,228,856,791.19** | **-** | **1,826,156,502.58** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **1,494,483,300.00** | **1,266,546,075.50** | **(227,937,224.50)** | **84.7%** |
| 21 | Урсгал зардлын дүн | 1,494,483,300.00 | 1,258,396,275.50 | (236,087,024.50) | 84.2% |
| **210** | **Бараа үйлчилгээний зардал** | **1,463,979,300.00** | **1,234,318,275.50** | **(229,661,024.50)** | **84.3%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,050,240,000.00** | **862,039,950.83** | **(188,200,049.17)** | 82.1% |
| 210101 | Үндсэн цалин | 528,536,600.00 | 425,432,975.66 | (103,103,624.34) | 80.5% |
| 210102 | Нэмэгдэл | 334,779,200.00 | 332,038,016.58 | (2,741,183.42) | 99.2% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 55,680,400.00 | 30,824,486.55 | (24,855,913.45) | 55.4% |
| 210104 | Урамшуулал | 131,243,800.00 | 73,744,472.04 | (57,499,327.96) | 56.2% |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 0.00 | - | 0.0% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **124,551,400.00** | **95,949,048.10** | **(28,602,351.90)** | **77.0%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 84,694,900.00 | 63,171,748.10 | (21,523,151.90) | 74.6% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,964,100.00 | 8,194,400.00 | (1,769,700.00) | 82.2% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,982,100.00 | 4,097,200.00 | (884,900.00) | 82.2% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,982,100.00 | 4,097,200.00 | (884,900.00) | 82.2% |
| 210205 | ЭМД-ын хураамж | 19,928,200.00 | 16,388,500.00 | (3,539,700.00) | 82.2% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **73,400,000.00** | **70,822,594.98** | **(2,577,405.02)** | **96.5%** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,700,000.00 | 7,935,667.98 | (1,764,332.02) | 81.8% |
| 210302 | Түлш, халаалт | 58,000,000.00 | 59,139,508.00 | 1,139,508.00 | 102.0% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,700,000.00 | 3,747,419.00 | (1,952,581.00) | 65.7% |
| 210304 | байрны түрээс | 0.00 | 0.00 | | 0.0% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **43,606,900.00** | **43,025,656.60** | **(581,243.40)** | **98.7%** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,825,700.00 | 4,761,950.00 | (63,750.00) | 98.7% |
| 210402 | Тээвэр шатахуун | 24,000,000.00 | 24,000,000.00 | - | 100.0% |
| 210403 | Шуудан холбоо | 2,357,900.00 | 2,117,286.60 | (240,613.40) | 89.8% |
| 210404 | Ном | 0.00 | - | - | 0.0% |
| 210405 | Хог хаягдал | 1,700,400.00 | 1,423,500.00 | (276,900.00) | 83.7% |
| 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл | 10,722,900.00 | 10,722,920.00 | 20.00 | 100.0% |
| **2105** | **Нормативт зардал** | **106,803,900.00** | **106,803,873.99** | **(26.01)** | **100.0%** |
| 210501 | Эм | 84,359,500.00 | 84,359,473.99 | (26.01) | 100.0% |
| 210502 | Хоол хүнс | 21,300,400.00 | 21,300,400.00 | - | 100.0% |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 1,144,000.00 | 1,144,000.00 | - | 100.0% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **40,721,200.00** | **31,301,484.00** | **(9,419,716.00)** | **76.9%** |
| 210601 | Багаж хэрэгсэл | 8,000,000.00 | 2,367,000.00 | (5,633,000.00) | 29.6% |
| 210602 | Тавилга | 2,750,000.00 | | (2,750,000.00) | 0.0% |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 1,901,900.00 | 1,901,900.00 | - | 100.0% |
| 210604 | Урсгал засвар | 28,069,300.00 | 27,032,584.00 | (1,036,716.00) | 96.3% |
| 2107 | Томилолт, зочны зардал | **2,944,100.00** | **2,942,000.00** | (2,100.00) | 99.9% |
| 210702 | Дотоод томилолт | 2,944,100.00 | 2,942,000.00 | (2,100.00) | 99.9% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр** | **11,157,200.00** | **10,846,037.00** | **(311,163.00)** | **97.2%** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,281,200.00 | 9,120,000.00 | (161,200.00) | 98.3% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,350,000.00 | 1,350,000.00 | - | 100.0% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 232,200.00 | 232,200.00 | - | 100.0% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 88,800.00 | 88,837.00 | 37.00 | 100.0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210805 | тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 55,000.00 | - | 100.0% |
| 210806 | мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 0.00 | - | 0.0% |
| 210807 | Газрын төлбөр | 150,000.00 | 0.00 | | 0.0% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **10,554,600.00** | **10,587,630.00** | **33,030.00** | **100.3%** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,554,600.00 | 10,587,630.00 | 33,030.00 | 100.3% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | - | - | 0.0% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **30,504,000.00** | **24,078,000.00** | **(6,426,000.00)** | **78.9%** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **-** | **-** | **-** | 0.0% |
| 213101 | Засгийн газрын дотоод урсгал шилжүүлэг | | | - | 0.0% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **30,504,000.00** | **24,078,000.00** | **(6,426,000.00)** | **78.9%** |
| 213204 | ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал | | | - | 0.0% |
| 213208 | хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 30,504,000.00 | 24,078,000.00 | (6,426,000.00) | 78.9% |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **8,149,800.00** | **8,149,800.00** | **0.0%** |
| | Дотоод эх үүсвэрээр | - | 8,149,800.00 | 8,149,800.00 | 0.0% |
| | Тоног төхөөрөмж | | | - | 0.0% |
| | Бусад хөрөнгө | | | - | 0.0% |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | **1,494,483,300.00** | **1,108,285,648.35** | **(386,197,651.65)** | **74.2%** |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | | | - | 0.0% |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | | - | 0.0% |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | | - | 0.0% |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | **79,400,000.00** | **76,697,264.98** | (2,702,735.02) | **96.6%** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 79,400,000.00 | 76,697,264.98 | (2,702,735.02) | 96.6% |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **1,415,083,300.00** | **1,007,362,383.37** | **(407,720,916.63)** | **71.2%** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 1,256,535,300.00 | 1,007,362,383.37 | (249,172,916.63) | 80.2% |
| | Урьд оны үлдэгдэл | 158,548,000.00 | | | |
| | ТӨСӨВ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | **0.00** | **24,226,000.00** | **24,226,000.00** | |
| | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 24,226,000.00 | 24,226,000.00 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 158,548,032.69 | 158,548,032.69 | 0.0% |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 287,605.54 | 287,605.54 | 0.0% |
| 1 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | - | 0.0% |
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.0% |
| 3 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.0% |
| | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 24.00 | 28.00 | 4.00 | 116.7% |
| | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0% |
| | Гүйцэтгэх ажилтан | 17.00 | 20.00 | 3.00 | 117.6% |
| | Үйлчлэх ажилтан | 6.00 | 7.00 | 1.00 | 116.7% |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эрүүл мэндийн төв нь "Үйлчилгээний соёлыг эрхэмлэн, иргэдэд нотолгоонд суурилсан эрүүл мэндийн анхан шатны болон уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай хүргэж эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд оршино." гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааг явуулсан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Эрүүл мэндийн тухай хууль, зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн бэлтгэсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Хонгор сумын Эрүүл мэндийн төв нь 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос149,777.7 мянган төгрөгөөр буюу 8.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 158,548.0 | 287.6 | (158,260.4) |
| Авлага | 22,551.4 | 154,156.6 | 131,605.2 |
| Бараа материал | 231,768.1 | 193,438.4 | (38,329.7) |
| Үндсэн хөрөнгө | 1,330,008.5 | 1,544,771.1 | 214,762.6 |
| **Нийт хөрөнгө** | **1,742,876.0** | **1,892,653.7** | **149,777.7** |
| Өр төлбөр | - | 66,497.2 | 66,497.2 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,742,876.0 | 1,826,156.5 | 83,280.5 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,742,876.0** | **1,892,653.7** | **149,777.7** |

Тайлант онд төрийн сангийн харилцах дансанд 287.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төлбөртэй үйлчилгээний авлагын үлдэгдэл 154,156.6 мянган төгрөг байгаа нь ЭМД-ын сангаас авах авлагатай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 193,438.4 мянган төгрөг болж 38,329.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 223,205.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Дархан-Уул аймгийн ЭМГ-ын даргын 2024 оны А/72 дугаар тушаалаар 6,072,9 мянган төгрөгийн эм, боох материал, 2,597.6 мянган төгрөгийн бусад хангамжийн материал буюу нийт 8,670.5 мянган төгрөгийн материал, ОНӨГ-ын даргын А/16 тоот тушаалаар 456.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасалт хийж бусад хангамжийн материал дансанд, тус ЭМТ-ийн даргын А/42, А/72 тоот тушаалаар 524.1 мянган төгрөгийн эм боох материалын тус тус шилжүүлэн бүртгэж, Нахиа, ЭХНБ аж нэгжүүдээс 26.1 мянган төгрөгийн эм, боох матерал, Хонгор сумын ИТХ-ын 2024 оны 19 тоот тогтоолоор 21,724.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг хандиваар авч, тайлант хугацаанд 228,345.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, тус эрүүл мэндийн төвийн даргын 2024 оны А/73 тоот тушаалаар 64,066.8 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,544,771.1 мянган төгрөг болж 214,762.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 8,149.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, ЭМ-ийн сайдын 2024 оны А/44, А/60, А/400 тоот тушаалаар 213,909.4 мянган төгрөгийн хөрөнгө, Хонгор сумын ИТХ-ын 2024 оны 19 тоот тогтоолоор 90,162.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж болон тавилга эд хогшил буюу нийт 304,071.3 мянган төгрөгийн хөрөнгийн хандиваар, ОНӨГ-ын даргын 2024 оны А/16 тоот тушаалаар 24 нэр төрлийн хөрөнгийг 9,504.7 мянган төгрөгөөр дахин үнэлж, ЭМГ-ын даргын А/12, А/202 тоот тушаалаар 1,040.7 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 108,004.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон нь нөлөөлсөн байна.

Богино хугацаанд төлөх өр төлбөрийн үлдэгдэл 66,497.2 мянган төгрөг байгаа нь ЭМД-ын сангаас авах авлага байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,826,156.5 мянган төгрөг болж 83,280.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДСангаас 1,473,761.7 мянган төгрөгөөр төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг нийт 259,769.9 бууруулж 1,213,991.8 мянган төгрөгөөр төсвийг баталсан.

Тайлант онд нийт батлагдсан төсвийг 201,091.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна

ЭМДСангаас гүйцэтгэлээрээ санхүүждэг болсонтой холбоотойгоор 1,415,083.3 мянган төгрөгийн санхүүжилт авах байснаас 1,007,362.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,415,083.3 мянган төгрөгийг ЭМД-н сангаас, 79,400.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөжээ.

. Гүйцэтгэлээр туслах үйл ажиллагаанаас 24,226.0 мянган төгрөгийн орлого, ЭМД-ын сангаас 1,007,362.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 1,189,848.8 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвөөс 79,400.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 76,697.3 мянган төгрөг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 2,702.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,269,248.8 мянган төгрөг буюу 84.7 хувьтай байгаа нь ЭМД-ын сангаас авах санхүүжилттэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| № | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | **71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | | | | |
| 1.1 | 80111-Төрийн эмчийн байгууллагын тогтмол зардал | 79,400.0 | 76,697.3 | 2,702.70 | 96.6% |
| 1.2 | 80302 Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон | 773,652.9 | 666,528.2 | (107,124.70) | 86.2% |
| 1.3 | 81603 Эхний үлдэгдэл | 158,548.0 | 158,548.0 | | |
| 1.4 | 81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 452,378.4 | 340,546.6 | (111,424.30) | 75.3% |
| 1.5 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 30,504.0 | 24,226.0 | (6,434,0) | 79.4% |
| **2.2** | **Нийт дүн** | **1,494,483.3** | **1,266,546.1** | **(215,846.3)** | **84.7%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д "Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 20 ажилтан, үйлчлэх 7 ажилтан буюу нийт 28 ажилтантайгаар ажиллаж, 210801- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 9,120.0 мянган төгрөг, 210901- Бараа үйлчилгээний бусад зардалд 10,587.6 мянган төгрөгийг тус тус зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой 48,720.1 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулж хоёр оролцогч шалгарсанбайна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаатай холбоотой 48,720.1 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулж хоёр оролцогч шалгарсанбайна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "ЦЭСБ-Аудит" ХХК-ийн аудитор Э.Эрдэнэбат гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Э.Эрдэнэбат, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эрүүл мэндийн төв 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,073,469.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,734.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах ...." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь*:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 585.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн биелэлт 100 хувийн хэрэгжилттэй байна.

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | тоо | дүн | тоо | дүн | хувь |
| Зөвлөмж | 3 | 585.0 | 3 | 585.0 | 100% |
| **Нийт дүн** | **3** | **585.0** | **3** | **585.0** | |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Мөн аудитаар нийт 751.2 мянган төгрөгийн зөрчил[1] илэрсэн тул төсөвт буцаан төвлөрүүлэх 751.2 мянган төгрөгийн актыг хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

<u>**5.1.1 Илрүүлэлт:**</u> Тус эрүүл мэндийн төвийн эх баригч, бага эмч Д.Энхцэцэг, эм найрруулагч М.Гэрэлмагнай, нягтлан бодогч Г.Ганчимэг нарт 751.2 мянган төгрөгийн ээлжийн амралтыг биеэр эдлүүлэхгүйгээр цалинг илүү бодож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*" гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж байхгүй.

Тайлангийн 4.2.2 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[2]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

[2] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтан | Тоо | Дүн |
| Тус эрүүл мэндийн төвийн эх баригч, бага эмч Д.Энхцэцэг, эм найрруулагч М.Гэрэлмагнай, нягтлан бодогч Г.Ганчимэг нарт 751.2 мянган төгрөгийн ээлжийн амралтыг биеэр эдлүүлэхгүйгээр цалинг илүү бодож олгосон | 1 | 751.2 | 1 | 751.2 | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **751.2** | **1** | **751.2** | | | - | - | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тус эрүүл мэндийн төв нь Ахмад настны тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| **Дүн** | **1** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **-** |